# ТАНИЛЦУУЛГА: ЭМНЭЛГИЙН УДИРДЛАГЫН БАГИЙН ЧИГ ҮҮРЭГ, АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ADB

МОН 9701, МОН 3843, МОН 3844 ТӨСӨЛ


Тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээний зөвлөх
Л.Баярцэцэг, С.Дэлгэрэх

ADB

ЧАНАР & ҮР АШИГ

## ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

# ЭМНЭЛГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа
- **Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа**
- Мэдээллийн үйл ажиллагаа
- Эмчилгээний үйл ажиллагаа
- Оношлогооны үйл ажиллагаа
- Дэмжих үйлчилгээний үйл ажиллагаа

ADB

ЧАНАР & ҮР АШИГ

# ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ЧАНАР &
ҮР АШИГ

# НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



# ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ: АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ




- **Ажлын байрны нэр:** *Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал*
- **Шууд тайлагнах албан тушаалтан:** *Эмнэлгийн захирал*
- **Ажлын байрны зорилго**:

*Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээ, технологийн шаардлагад нийцсэн, чанартай, зардлын хувьд үр ашигтай тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах ба чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах ажлыг эмнэл зүй эрхэлсэн дэд захирал, чанар, аюулгүй байдлын албатай хамтарч хангуулна.*

- **Ажлын байрны үндсэн чиг үүрэг:**

- *Эмнэлгийн эмнэл зүйн болон эмнэл зүйн бус бүхий л хэсгийг удирдаж, бүх нэгжүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.*
- *Эмнэлгийн нөөцийн ашиглалтыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг удирдана.*
- *Эмнэлгийн хангамжийн менежментийг хариуцаж удирдана.*
- *Төсвийн жилийн эхэнд төсөвтөө тохируулан тухайн жилийн төлөвлөлтийг хийнэ.*
- *Эмнэлгийн дүрэм, журмыг эмнэлгийн үйл ажиллагаатай уялдуулан тогтоох ажлыг удирдана.*
- *Эмнэлгийн дээд түвшний менежерүүдийн үйл ажиллагааг уялдуулж, нэгдсэн удирдлагаар хангана.*
- *Үр дүнтэй систем, үйл явц, гүйцэтгэлийн менежментийн хэрэгжүүлэх ажлыг хариуцана.*
- *Эмнэлгийн гүйцэтгэлийн үнэлгээг удирдан зохион байгуулна.*
- *Эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд дэх хөгжил, шинэчлэл, инновацийг идэвхжүүлэх, үйлчилгээг тасралтгүй сайжруулах соёлыг бүрдүүлэх үйл ажиллагааг хариуцаж ажиллана.*

# АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ: АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

| Тавигдах шаардлага | Зайлшгүй шаардлагатай | Байвал зүгээр | Үнэлгээний арга |
|---|---|---|---|
| **МЭРГЭЖИЛ** | | | |
| ▪ Боловсролын зэрэг, мэргэшсэн байдал | √ | | Анкет |
| ▪ Дээд түвшний менежерийн гүйцэтгэх чиг үүрэгтэй уялдсан ур чадвар, чадахуйн дадал эзэмшсэн байдал | √ | | |
| **МЭДЛЭГ БА ТУРШЛАГА** | | | Анкет \танилцуулга\ ярилцлага\ |
| ▪ Эмнэлгийн үйл ажиллагааг удирдах арвин туршлагатай | √ | | |
| ▪ Олон төрлийн багуудын үйл ажиллагааг уялдуулж, манлайлах чадвартай | √ | | |
| ▪ Эмнэлгийн гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чадвартай, ажлын туршлагатай | √ | | |
| ▪ Бусад байгууллага, хамтрагч талуудтай бүх төрлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, олон талт харилцааг бий болгох, олйголцлын зөв таатай орчинг бүрдүүлэх туршлага, чадвартай | √ | | |
| ▪ Асуудалтай, бэрхшээлтэй орчинд томоохон цогц өөрчлөлтийг манлайлах, үр дүнтэй удирдаж байгууллагын зөв соёлыг бүрдүүлэх ажлын туршлагатай | √ | | |
| ▪ Тусламж, үйлчилгээний үйл явцын зураглал, үйлчилгээний дизайнд суурилсан үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах ажлыг удирдах мэдлэг, чадвартай, туршлагатай | √ | | |
| ▪ Эмнэлгийн процессыг үйлдвэрлэлийн процесстой адилтган үйл ажиллагаанд нэвтрүүлэх инновацийн боломжуудыг олж харах чадвартай | √ | | |
| ▪ Үйл ажиллагааны зардлыг бууруулах, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх удирдлагыг хэрэгжүүлэх мэдлэг, чадвар, ажлын туршлагатай | √ | | |

ЧАНАР & ҮР АШИГ

# Тусгай мэргэжлийн төвийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн онцлог












"**ХӨСҮТ** нь халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа, оношлогоо, эмчилгээний асуудлыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий тусгай мэргэжлийн төв байгууллага юм".



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА